

**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ
ВИЗНЭЭС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ
ЭНЭТХЭГ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар (цаашид «Хэлэлцэн тохирогч талууд» гэх),

Хоёр орны хоорондын найрсаг харилцааг цаашид бэхжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэж,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл

Өөрийн орны эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр дипломат, эсхүл албан паспорт эзэмшиж буй Монгол Улсын иргэд болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын иргэд хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутаг дэвсгэрт ерэн (90) хоногоос илүүгүй хугацаагаар зорчих, байхаар бол холбогдох визнээс чөлөөлөгдөнө.

2 дугаар зүйл

1. Хүчин төгөлдөр дипломат, эсхүл албан паспорттой хэлэлцэн тохирогч аль нэг талын иргэн хэлэлцэн тохирогч нөгөө талд дипломат болон консулын төлөөлөгчөөр томилогдсон бол хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэхдээ виз авах шаардлагагүй бөгөөд холбогдох дипломат болон консулын байгууллагын хүсэлтээр ирснээс нь хойш 90 хоногийн дотор албан ёсоор байх хугацааны визийг түүнд олгоно.

2. Хүчин төгөлдөр дипломат, эсхүл албан паспорт эзэмшиж байгаа хэлэлцэн тохирогч аль нэг талын иргэн хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт орших олон улсын байгууллагад өөрийн улсаа төлөөлж байгаа бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийг эдэлнэ.

3. 1 болон 2 дахь хэсэгт дурдсан хөнгөлөлтийг дипломат буюу консулын байгууллагын гишүүн, эсхүл олон улсын байгууллагын ажилтны дипломат, эсхүл албан паспорт эзэмшиж байгаа гэр бүлийн гишүүн болон тэдний хүүхдүүд мөн эдэлнэ.

3 дугаар зүйл

2 дугаар зүйлд дурдсанаас бусад тохиолдолд хэлэлцэн тохирогч аль ч талын хүчин төгөлдөр дипломат, эсхүл албан паспорт эзэмшигч иргэд хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт ерэн (90) хоногоос дээш хугацаагаар байх тохиолдолд

хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт визгүй нэвтэрч болох бөгөөд ирснээсээ хойш 90 хоногийн дотор хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагад холбогдох виз авахаар мэдүүлнэ.

4 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийн дагуу визнээс чөлөөлөх нь дээр дурдсан паспорт эзэмшигчдийг хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэх, байх, дамжин өнгөрөх болон гарахтай холбоотой хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль болон дүрмийг дагаж мөрдөхөөс чөлөөлөхгүй.

5 дугаар зүйл

Хэрэв хэлэлцэн тохирогч аль нэг талын иргэн хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт өөрийн паспортаа гээвэл тэрбээр хүлээн авагч тухайн орны холбогдох байгууллагад хандаж зохих арга хэмжээ авахуулна. Холбогдох дипломат төлөөлөгчийн газар буюу консулын газар нь өөрийн иргэнд шинэ паспорт, эсхүл зорчих үнэмлэх олгох бөгөөд энэ тухайгаа хүлээн авагч улсын засгийн газрын холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч тал бүр аливаа этгээдийг өөрийн хууль тогтоомжийн дагуу оруулах буюу байлгах нь тааламжгүй гэж үзвэл нутаг дэвсгэртээ оруулах буюу байлгах зөвшөөрөл олгохоос татгалзах эрхээ хадгална. Ийнхүү татгалзсан тухайгаа хэлэлцэн тохирогч нөгөө талд дипломат шугамаар мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль ч тал аюулгүй байдлаа хангах, нийтийн дэг журам сахиулах, эсхүл нийтийн эрүүл мэндийг хамгаалах, эсхүл хууль тогтоомжоо биелүүлэх шалтгаанаар энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно. Ийнхүү түр зогсоосон болон зогсоосноо цуцалсан тухайгаа хэлэлцэн тохирогч нөгөө талд дипломат шугамаар даруй мэдэгдэх бөгөөд энэ мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн тэр нь хүчин төгөлдөр болно.

8 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө өөрийн оронд хүчин төгөлдөр байгаа дипломат болон албан паспортын загварыг дипломат шугамаар солилцоно.

2. Хэрэв хэлэлцэн тохирогч аль нэг талын дипломат, эсхүл албан паспорт шинэчлэгдсэн, эсхүл өөрчлөгдсөн бол хэлэлцэн тохирогч тухайн тал шинэ паспортыг хэрэглээнд гарахаас гуч (30) хоногийн өмнө түүний загварыг дипломат шугамаар хэлэлцэн тохирогч нөгөө талдаа өгнө.

9 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурснаас хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Энэхүү хэлэлцээр тодорхойгүй хугацаанд үйлчилнэ. Хэлэлцэн тохирогч аль нэг тал дипломат шугамаар мэдэгдэж түүнийг цуцалж болох бөгөөд ийнхүү мэдэгдсэнээс хойш ерэн (90) хоногийн дараа цуцлалт нь хүчин төгөлдөр болно.

ДЭЭР ДУРДСАНЫГ ГЭРЧИЛЖ, тус тусын Загийн газраас зохих ёсоор бүрэн эрх олгосон этгээдүүд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

2005 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Шинэ Дели хотноо монгол, хинди, англи хэлээр хоёр (2) эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг